

ДЭЭД БОЛОВСРОЛЫН ШИНЭЧЛЭЛ: ИХ СУРГУУЛИЙН ЗАСАГЛАЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

# ДЭЭД БОЛОВСРОЛЫН ЗАСАГЛАЛ: БОДЛОГЫН ШИЙДЭЛ, СУРГАМЖ

Р. Бат-Эрдэнэ

Монголын Америк Их сургууль

# АГУУЛГА

- Дээд боловсролын хөгжлийн хүчин зүйлс
- Дээд боловсролын засаглал ба автономи
  - Төрийн чиг үүрэг, ашиг сонирхол
  - Автономи олон улсад: хяналтаас зохицуулалтад
- Монгол дахь бодлогын шийдэл
- Сургамж


**Дээд боловсролын хөгжлийн хүчин зүйлс**

Дээд боловсролын засаглал

# ДЭЭД БОЛОВСРОЛЫН ХӨГЖЛИЙН СУРВАЛЖ

- **Өөрчлөлтөд хөтлөгч хүчин зүйлс:**
  - Өсөн нэмэгдэж буй глобальчлал, харилцан холбоо хамаарал, орон зайн хүчин зүйл
  - Мэдлэг, бүтээлч сэтгэлгээ нь байгалийн нөөц, биет капиталаас илүүтэйгээр эдийн засгийн өсөлтийг тодорхойлогч үйлдвэрлэлийн хүчин зүйл болсон:  
сүүлийн 40 жилд ‘БНСУ – Бразил’-ийн хөгжилд гарсан зөрөө
- **Нийтлэг шийдэл:** мэдлэгийн секторын динамизм, өрсөлдөх чадварыг сайжруулахад тэргүүлэх ач холбогдол өгөх
- **Үндэсний боловсролын системийн зорилго:**
  - Хамралтыг нэмэгдүүлэх (хэмжээ)
  - Чанарыг сайжруулах (үнэ цэнэ)

# Баян ядуугийн ялгаа нь мэдлэгийг хэрхэн ашигласнаас хамаарна



# ДЭЭД БОЛОВСРОЛЫН ХӨГЖЛИЙН ОЛОН УЛСЫН ХАНДЛАГА

- Цар хүрээний тэлэлт:

элит  масс  универсал

- Төрийн оролцоо, зохицуулалт: боловсролын чанар, өгөөжийг үнэлэх, хөгжлийн стратегийг шинэчлэх нийтлэг үйл явц
- Өрсөлдөөний огцом өсөлт: хил дамнасан нийлүүлэлт (үйлчилгээ), шинэ нийлүүлэгчид, вирчуал их сургууль, корпоратив их сургууль

ЧАНАРЫН ЗОХИЦУУЛАЛТ: МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ, КРЕДИТ  
ТРАНСФЕР

- Төрийн дэмжлэгийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хувийн хэвшлийн оролцоог урамшуулах: ‘БНСУ – Гана’, ‘Малайз – Замби’-гийн хөгжлийн сүүлийн 40 жилийн зөрөө нь дээд боловсролын хувийн секторын оролцооноос хамаарсан. ‘ашгийн төлөө’ сургуулийн өсөлт.

Эх сурвалж: Daniel, J., Kanwar, A. & S. Uvalic-Trumbic (2006).  
A Tectonic Shift in Global Higher Education, Change,

**Дээд боловсролын засаглал ба автономи**  
**Төрийн чиг үүрэг, ашиг сонирхол**  
**Автономи олон улсад: хяналтаас зохицуулалтад**

Дээд боловсролын засаглал

# ТӨР БА ДЭЭД БОЛОВСРОЛ

“засаглал” нь дээд боловсролын хүрээнд ажиллаж буй байгууллага, хүмүүсийн харилцааг төлөвлөх, чиглүүлэхтэй холбогдсон бүтэц, процесс, үйл ажиллагааны систем (John Fielden, 2008)

- Дээд боловсрол нь улам бүр комплекс болж байна: хамралт оролцоо, сургууль байгууллагын тоо, төрөл хэлбэрийн тасралтгүй өсөн тэлэлт.
- дээд боловсролын үйлчилгээ нь хил хязгаарт баригдахаа больсон (offshore campuses, online education).
- Боловсролын асуудал зөвхөн боловсролын яамны эрх хэмжээнээс хальдаг (Батлан хамгаалах, Хуульзүйн болон бусад яамдын эрх мэдэл, ашиг сонирхол)
- Дээд боловсрол нь улам бүр насан туршийн үйл ажиллагаа болж буй тул хүмүүс энэ үйлчилгээг авахаар хэд хэдэн удаа ханддаг болж буй.
- Аливаа дэвшил хөгжилд үүсгэж байгааг саад бартааг арилгах нь хууль тогтоогчдын үүрэг болж байна; сургуулиуд хувьсан өөрчлөгдөж байхад хууль тогтоомж үүнийг гацаах хэрэгсэл болж болохгүй.

# ТӨР, ИХ СУРГУУЛИЙН ХАРЬЦАА

Төрийн оролцоо ямар хэмжээнд байх ёстой вэ:

- Сургуулийн удирдах албан тушаалтныг томилоход зөвшөөрөл хэрэгтэй эсэх?
- Сургуулийн эрхэм зорилго, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, баримтлахад төрийн оролцоо
- Сургуулийн менежментийг сайжруулахад төр хэрхэн оролцох
- Өмч хөрөнгийг хөдөлгөх, зээл авахад төрөөс хэрхэн оролцох
- Төрийн оролцоо зайлшгүй хэрэгтэй юу?

# АВТОНОМИ

*Төр засгаас хамааралгүйгээр ажиллаж болох чадамж*

- Иргэдийн тухайд:
  - Бүтээлээ нийтлүүлэх, нийтэд дуу хоолойгоо хүргэхэд эдлэх академик эрх чөлөө
  - Нийгэм, зах зээлийн эрэлт хэрэгцээг тусгасан хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх эрх чөлөө
  - Сонирхсон чиглэлээрээ судалгаа хийх эрх чөлөө
- Их сургуулийн тухайд:
  - Хөгжлийн стратегиа тодорхойлох, хэрэгжүүлэх
  - Оюутнаа сонгох, элсүүлэх (тохиролцсон тоо хэмжээний хүрээнд)
  - Тохиролцсон хэмжээний төсвийг хэрэгцээндээ нийцүүлэн захирч зарцуулах

(John Fielden, 2008)

# ТӨРИЙН БҮРЭН ХЯНАЛТААС АВТОНОМИ ХҮРТЭЛ

## Хуулийн нийтлэг зохицуулалт:

- Яам, буфер байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээ (санхүү, хөрөнгө нөөцийн хуваарьлалтын талаархи эрх мэдлийг оролцуулан)
- Их сургуулийн автономии, академик эрх чөлөөг хангах
- Автономи эрхтэй их сургуулийн удирдах зөвлөлийн чиг үүрэг, эрх хэмжээ
- Сайдын эрх хэмжээ, хариуцах асуудал

| Сургуулийн засаглалын модель | Нийтийн их сургуулийн статус                                                                                                                                | жишээ                |
|------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------|
| А. Төрийн хяналт             | Яамны агентлаг, эсвэл төрийн мэдлийн корпораци                                                                                                              | Малайз               |
| В. Хагас автономии           | Яамны агентлаг, эсвэл төрийн мэдлийн корпораци, эсвэл хуулийн бие даасан этгээд                                                                             | Шинэ Зеланд, Франц   |
| С. Хагас бие даасан          | Яамны хяналтын хүрээнд хуулийн бие даасан этгээд, чарити, эсвэл ашгийн бус корпораци                                                                        | Сингапур             |
| Д. Бие даасан                | Засгийн газрын оролцоо, хяналтаас чөлөөт хуулийн бие даасан этгээд, чарити, эсвэл ашгийн бус корпораци (үндэсний стратегитэй уялдсан төсвийн санхүүжилттэй) | Австрали, Их Британи |

# ТӨВ БАЙГУУЛЛАГАД ҮЛДЭЭХ ЭРХ МЭДЭЛ

Засгийн газар/яаманд үлдээж буй стратегийн чиг үүрэг:

- Ерөнхий бодлогыг тодорхойлох, салбарын “хэмжээ, төрх”-ийг тогтоох (нийтийн ба хувийн хэвшлийн харьцаа, сургуулийн хэв шинж, г.м.)
- Салбарын стратеги төлөвлөлт (тухайлсан сургууль байх албагүй)
- Нийт төсвийн хэмжээг Сангийн яамтай зөвшилцөх
- Бусад яамдтай харилцааг зохицуулах (эрүүл мэнд, хөдөө аж ахуй, г.м.)
- Эрх мэдэл шилжүүлэн авах бусад байгууллагын чиг үүргийг тодорхойлох (буфер агентлаг, албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн Захирлуудын хороо, г.м.)

**Сүүлийн жилүүдэд гарч буй өөрчлөлт:**

- Засгийн газрын төв байгууллагаас дараагийн шатны байгууллагад эрх мэдлийг шилжүүлэх,
- Эрх мэдлийг буфер байгууллагад шилжүүлэх, эсвэл
- Их сургуульд эрх мэдлийг шилжүүлэх.

# БУФЕР БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ

| Улсын нэр                                                     | B | C | D | E | F | G | H | I | J |
|---------------------------------------------------------------|---|---|---|---|---|---|---|---|---|
| Стратеги төлөвлөлт                                            |   |   |   |   |   |   |   |   |   |
| Бодлогын шинжилгээ/ асуудал шийдвэрлэх                        |   |   |   |   |   |   |   |   |   |
| Их сургуулийн эрхэм зорилго (үндсэн чиг үүрэг)-ыг тодорхойлох |   |   |   |   |   |   |   |   |   |
| Академик хөтөлбөрийг хянах                                    |   |   |   |   |   |   |   |   |   |
| Төсвийг төлөвлөх/ санхүүжүүлэх зөвлөгөө/ хуваарилалт          |   |   |   |   |   |   |   |   |   |
| Хөтөлбөрийн удирдлага                                         |   |   |   |   |   |   |   |   |   |
| Хяналт-шинжилгээ/ хариуцлага                                  |   |   |   |   |   |   |   |   |   |
| Чанарын үнэлгээ/ стандартын хяналт                            |   |   |   |   |   |   |   |   |   |
| Элсэлтийн тоог тогтоох, хянах                                 |   |   |   |   |   |   |   |   |   |

B = Канад (Манитоба)      C = Гонгконг      D = Энэтхэг      E = Кени      F = Нигер      G = Өмнөд Африк  
 H = Шри Ланк      I = Англи      J = Зимбабве

Source: CHEMS Online Paper no 27. *Buffer Organizations in higher education: illustrative examples in the Commonwealth*. 1998. (Modified by Fielden (2008) in 2006)

Нэг буюу хэд хэдэн буфер байгууллагад эрх мэдэл шилжүүлэх нь Британий нөлөөний орнуудад нэлээд эртнээс тогтсон практик юм. Хамгийн түгээмэл шилжүүлдэг эрх мэдэл нь санхүүжилт, үйл ажиллагааны менежмент, харин үндэсний хэмжээний стратеги, нийт системийн цар хүрээ, ерөнхий төрхийг тодорхойлох асуудлыг төв засгийн газарт үлдээдэг.

# ТӨРИЙН ЧИГ ҮҮРЭГ, АШИГ СОНИРХОЛ

- Дээд боловсролын талаар төрөөс дэвшүүлсэн бодлогын зорилго, зорилтод хүрэх
- Дээд боловсролын тэгш байдал, хүртээмжийг баталгаажуулах
- Чанарын баталгаажуулах, бэхжүүлэх
- Өртөг зардлыг зохистой хэмжээнд байлгах (эцэг эх, суралцагч, бизнесийнхэнтэй зардлыг хуваалцах)
- Үндэсний эрдэм шинжилгээний чадавхийг бэхжүүлэх

# ХАРИУЦЛАГА

Их сургуулиуд бие даахын чацуу дараах хариуцлага хүлээнэ:

- үндэсний хэмжээний бодлого, зорилттой нийцэж байх
- сургалт, судалгааны чанарыг хангах
- санхүү нь шударга, зарцуулалт нь үр ашигтай байх
- удирдлага, засаглал нь үр нөлөөтэй байх

# Хариуцлагажуулах арга

- Үндэсний хэмжээний зорилго
- Сургалтын чанар
- Санхүү
- Сайн засаглал
- Үйл ажиллагааны үр дүнг яам үнэлэх
- Чанарын хөндлөнгийн үнэлгээ, дотоод хяналт
- Санхүүгийн тайлан, аудит
- Үечилсэн тайлан, статистик

# ОЛОН УЛСЫН ХАНДЛАГА

- Автономийг нэмэгдүүлэх ерөнхий чиг хандлагатай (Японы шинэ хууль, АНУ-ын зарим муж улс).
- Яамд зарим чиг үүргээ буфер байгууллага, дундын байгууллагад шилжүүлж байна
- Гэвч засгийн газрын зүгээс хянах, тайлан шаардах нь нэмэгдэж байна
- Хяналт үнэлгээний байгууллагын тоо нэмэгдэж байна (чанарын хяналт, г.м.)

(Fielden, 2008)

# Засаглалын туйлын модел - орлого

## Төр хянадаг

- Яамны грант 95%
- Оюутны төлбөр 3%
- Бусад төлбөр 2%


## Автономи

- Яамны грант 40%
- Оюутны төлбөр 25%
- Судалгаа, гэрээт ажил 20%
- Бусад орлого 10%
- Бэлэг хандив 5%

# Их Британий Их сургуулиудын орлогын жишээ (2007)

|                                | <b>UCL (\$907m)</b><br>(Times # 7) | <b>Kings College London</b><br>(\$609m) (Times # 22) |
|--------------------------------|------------------------------------|------------------------------------------------------|
| Засгийн газрын грант           | 29%                                | 34%                                                  |
| Дотоодын сургалтын төлбөр      | 8%                                 | 12%                                                  |
| Гадаад оюутны сургалтын төлбөр | 10%                                | 6%                                                   |
| Судалгааны орлого              | 33.5%                              | 27%                                                  |
| бусад (байр сууц г.м.)         | 18%                                | 19%                                                  |
| Хөрөнгийн зах зээлийн орлого   | 1.5%                               | 2%                                                   |

# Их сургуулийн орлогын бүтцийг харьцуулбал



# Засаглалын туйлын модел - ХҮМҮҮС

## Төр хянадаг

- Дээд удирдлагыг томилох, дэвшүүлэхийг яам шийддэг
- Бүх шатны ажилтны цалингийн хэмжээ, ажлын цагийг улсын хэмжээнд хатуу тогтоосон
- Орон тооны квотыг хатуу тогтоосон
- Багш судлаачдад насан туршийн тенюр

## Автономи

- Ажилтнуудаа сонгох, дэвшүүлэх эрх мэдэл
- Сургуулийн цалингийн схемтэй, тохиролцоо хийх боломжтой
- Цалин хөлс нь ажлын үр дүн, зах зээлийн нөхцөл байдлыг тусгах боломжтой
- Тенюрийг хорогдуулж, гэрээт ажилтныг нэмэгдүүлэх төлөвтэй

# Засаглалын туйлын модел – өмч хөрөнгө

## Төр хянадаг

- Бүх өмч төрийн мэдэлд
- Өмчийг устгах/ нэмэгдүүлэх нь хатуу хяналттай
- Хувийн хэвшлээс зээл авах, хамтарсан хөрөнгө оруулалт хийхийг хориглосон
- Оюутан сургах тоо, байр талбайн ашиглалтыг төр зохицуулна

## Автономи

- Хөрөнгийг их сургууль өмчилж болно
- Өмч устгах, шинээр авах нь зөвшөөрөгдсөн
- Хөрөнгө оруулагч, банк, бусад талтай түншилж, хамтрах боломжтой
- Байр талбайг ашиглах шийдвэр гаргана

# OECD зарим гишүүн орон дахь их сургуулийн автономи

| Улсын нэр  | Төрийн<br>байрыг<br>өмчлөх | Зээл<br>авах | Төсвөө<br>захиран<br>зарцуулах | Бүтэц,<br>хөтөлбөрөө<br>тогтоох | Ажилд<br>авах,<br>халах | Цалинг<br>тогтоох | Элсэлтийн<br>тоогоо<br>тогтоох |
|------------|----------------------------|--------------|--------------------------------|---------------------------------|-------------------------|-------------------|--------------------------------|
| Мексик     | Ү                          |              | Ү                              | Ү                               | Ү                       |                   | Ү                              |
| Голланд    | Ү                          | Ү            | Ү                              |                                 | Ү                       | Ү                 | Ү                              |
| Польш      | Ү                          | Ү            | Ү                              | Ү                               | Ү                       |                   | Ү                              |
| Австрали   | Ү                          |              | Ү                              | Ү                               | Ү                       | Ү                 |                                |
| Ирланд     | Ү                          |              | Ү                              | Ү                               | Ү                       |                   | Ү                              |
| Их Британи | Ү                          | Ү*           | Ү                              | Ү                               | Ү                       | Ү                 |                                |
| Дани       |                            | Ү            | Ү                              |                                 | Ү                       |                   | Ү                              |
| Швед       |                            |              | Ү                              | Ү                               | Ү                       | Ү                 |                                |
| Норвег     |                            |              | Ү                              | Ү                               | Ү                       |                   | Ү                              |
| Финлянд    |                            |              | Ү                              |                                 | Ү                       | Ү                 |                                |
| Австри     |                            |              | Ү                              | Ү                               | Ү                       | Ү                 |                                |

**Монгол дахь бодлогын шийдэл**

Дээд боловсролын засаглал

# МОНГОЛЫН ДЭЭД БОЛОВСРОЛ 1990 ОНООС ХОЙШ

- Улс төрийн эрх мэдлийн шинэчлэл:
  - 90-ээд оны эхэн үеэс өргөн хүрээтэй либеральчлал
  - эхэн дунд үед засгийн шинэчлэл, улс төрийн системийн ардчилалд чиглэсэн реформын суурь алхмууд
  - дунд үеэс хойш төрийн үйлчилгээний төвлөрлийг буцаан сэргээх хандлага.
- Хууль тогтоомжийн мөн чанар, боловсруулсан арга зам: томоохон өөрчлөлт нь холбогдох талуудын өргөн оролцоотой салбарын судалгаа, мастер төлөвлөгөөнд суурилсан (1993, 2004 онд)

# БОЛОВСРОЛЫН ХУУЛЬ ТОГТООМЖИД ОРУУЛСАН ӨӨРЧЛӨЛТ

- Боловсролын хууль 1991 онд
- Боловсролын багц хууль 1995 онд
  - Нэмэлт өөрчлөлт 1998, 2000 онд
- Шинэчлэн найруулсан багц хууль 2002 онд
  - Нэмэлт өөрчлөлт 2006, 2009, 2011, 2012 онд
- Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль 2002 онд
- Төрийн албаны тухай хууль 2002 онд
- Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль 2011 онд
  - Нэмэлт өөрчлөлт 2012 онд

# БОДЛОГЫН ШИЙДЭЛ: ХАРИЛЦААНЫ ЗАРЧИМ

1991: төрийн ивээл, хяналтанд байх

1995: тэргүүлэх салбар болгон хөгжүүлж, төрийн ивээл, зохицуулалт, төр, олон нийтийн хяналтанд байлгана

өмчийн төрөл, хэлбэрийг харгалзахгүйгээр адил тэгш хандана

2002: тэргүүлэх салбар болгон хөгжүүлж, төрийн ивээл, зохицуулалт, төр, олон нийтийн хяналтад байлгана

өмчийн төрөл, хэлбэрийг харгалзахгүйгээр сургуулиудад адил тэгш хандана

# БОДЛОГЫН ШИЙДЭЛ: БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТӨРӨЛ ХЭЛБЭР

1995: боловсролын байгууллага нь ашгийн төлөө бус статустай байна

1998: Төрийн бус өмчийн боловсролын байгууллага нь ашгийн төлөө буюу ашгийн төлөө бус байж болно.

2002: боловсролын байгууллага нь ашгийн төлөө бус;

2006: боловсролын байгууллагыг ашгийн төлөө бус, ашгийн төлөө гэж ангилна.

---

Дээд боловсролын сургалтын байгууллага:

1995: их сургууль, дээд сургууль, коллеж

1998: их сургууль, коллеж

2002: их сургууль, дээд сургууль, коллеж

# МОНГОЛ УЛСЫН ДЭЭД БОЛОВСРОЛЫН САЛБАР

|      | Нийт<br>суралцагчид | Сургуулийн тоо |        |        | Дундаж<br>төлбөр | Нэг оюутанд<br>олгосон санхүүжилт |
|------|---------------------|----------------|--------|--------|------------------|-----------------------------------|
| он   |                     | бүгд           | төрийн | хувийн | Мянган төгрөгөөр |                                   |
| 1990 | 17,338              | 8              | 8      |        |                  |                                   |
| 1993 | 24,630              | 55             | 24     | 31     | 36.1             | 36.1                              |
| 1996 | 44,088              | 75             | 24     | 51     | 69.6             | 69.6                              |
| 1999 | 74,025              | 118            | 32     | 86     | 239.2            | 239.2                             |
| 2000 | 84,985              | 172            | 38     | 134    | 239.2            | 260.2                             |
| 2004 | 123,824             | 184            | 49     | 135    | 249.4            | 256.5                             |
| 2008 | 161,111             | 154            | 48     | 106    | 455.1            | 382.0                             |
| 2011 | 172,798             | 101            | 15     | 86     | 817.9            | 712.8                             |

# БОДЛОГЫН ШИЙДЭЛ: БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА

1991: үйл ажиллагаанд хяналт тавих, туслах  
зорилготой ажилтнууд, олон нийтийн  
төлөөлөлтэй зөвлөл байж болно;

Сургуулийн хамт олноос сонгосон захирал

1995: сургуулийн эрхийг барих Удирдах зөвлөл нь  
үүсгэн байгуулагч, багш, суралцагчид болон  
тэдгээрийн эцэг эхийн төлөөлөлтэй

Захирлыг удирдах зөвлөл томилж, яам батламжилна

1998: удирдах зөвлөлийн гишүүдийн 51-60 хүртэлх  
хувь үүсгэн байгуулагчийн төлөөлөл

2002: захирлыг гаднаас томилно

Төсвийн ерөнхийлөн захирагч төрийн өмчийн сургуулийн  
менежер-захирлыг томилно

# БОДЛОГЫН ШИЙДЭЛ : СУРГАЛТЫН АГУУЛГА, СТАНДАРТ

- 1991: яам нь мэргэжлийн боловсролын төвшинг тогтоож, агуулгын нэгдсэн бодлого боловсруулж зохицуулна  
Төрөөс хуульчлан тогтоосон сургалт-эрдэм шинжилгээний төвшинг хангасан их сургууль үйл ажиллагаагаа хууль тогтоомжийн хүрээнд бие даан явуулна
- 1995: Боловсролын агуулгыг хуулиар тодорхойлж, **стандартаар** нарийвчлан тогтооно. Боловсролын стандарт нь суралцагчид зайлшгүй эзэмшсэн байх агуулга, түүний үнэлгээ, багшийн мэргэжлийн түвшин, сургалтын байгууллагад тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлно
- 2002: яам бүх шатны боловсролын **стандарт**, норм, норматив боловсруулах, дээд боловсролын мэргэжлийн чиглэлийг тогтоох;

# БОДЛОГЫН ШИЙДЭЛ: САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР

1991: улс, орон нутгийн төсөв, байгууллага, иргэдээс оруулах сургалтын төлбөр, хандив

*Өмчийн бусад хэлбэрийн байгууллагад төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.*

1995: төвлөрсөн болон орон нутгийн төсөв, хөрөнгө оруулалт, сургалтын төлбөр, хандив, зээл, өөрийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого зэрэг

*Төрийн бус өмчийн байгууллагын материаллаг бааз, багшлах боловсон хүчнээр хангахад Засгийн газар тогтоосон журмын дагуу дэмжлэг, туслалцаа үзүүлнэ*

1998: Ашгийн төлөө бус байгууллага нь хоёр жил тутамд санхүүгийн аудитын хяналт хийлгэж, дүнг нийтэд ил тод байлгана (ДБТХ)

2002: төрийн өмчийн байгууллага зээл авахыг хориглосон (ТБУСИХ)

*Төрийн бус өмчийн байгууллагын сургалтын орчинг сайжруулах, тэдгээрийг багшлах боловсон хүчнээр хангахад Засгийн газар тогтоосон журмын дагуу дэмжлэг, туслалцаа үзүүлнэ*

2011 (ДБССНБТХ): үүсгэн байгуулагчаас шилжүүлсэн хөрөнгө; улсын төсөв; эрдэм шинжилгээ, судалгааны ажлын санхүүжилт; сургалтын төлбөр; гэрээт ажил, үйлчилгээ, аж ахуйн орлого; **эдийн засгийн сонирхолгүйгээр шилжүүлсэн хөрөнгийг эргэлтэд оруулснаас олсон орлого**; хандив, тусламж, бэлэг; зээл;

**Сургамж**

Дээд боловсролын засаглал

# ӨНГӨРСНӨӨС АВАХ СУРГАМЖ

- Өмнөх системийн концепцийг өөрчилсөн нь бүх оролцогчдод ойлгомжтой эсэх
- Парадигмийн өөрчлөлт хийх чадамжийг бүх шатанд бүрдүүлэх: хууль тогтоох, хэрэгжүүлэх, үнэлж шинжлэх
- Өөрчлөлтийг удирдах хүний нөөцийн чадавхи
- Институцийн бүрдэл: засгийн газар, их сургуулийн удирдлага, мэргэжлийн олон нийт, хөндлөнгийн үнэлгээ, санхүүжүүлэх, хөрөнгө оруулах, дэмжлэг үзүүлэх хөрс

# БУСДЫГ ХАРВАЛ...

- Шилдэг их сургуулиудын ажиллаж байгаа нь орчин нь эрүүл өрсөлдөөн, эрдмийн чөлөөт эрэл хайгуул, шүүмжит сэтгэлгээ, инноваци, бүтээлч хандлагыг хөхүүлэн дэмжсэн зохицуулалттай байна.
- **Автономи эрхтэй** сургууль л уян хатан бөгөөд үр ашигтай ажиллаж байна. Учир нь эдгээр байгууллага хүнд суртлын дарамт, гаднаас тулгасан стандартаас чөлөөтэй, гэхдээ академик ёсзүй, үнэт зүйлсэд нийцсэн хариуцлагын механизмд захирагддаг. Үүний дүнд эдгээр сургууль нөөц боломжоо зохистой хуваарилан зарцуулж, эрс хурдсан өөрчлөгдөж буй глобал зах зээлийн эрэлтэд шуурхай хариу үзүүлж байна.
- Их сургуулийн үйл ажиллагааг урамшуулан сайжруулахын тулд санхүүжилт, зохицуулалт нь:
  - үйл ажиллагаанд суурилсан санхүүжилтийн зарчимд шилжиж, төрөөс санхүүжүүлэх хөрөнгийг олон сувагтай болгох шаардлагатай
  - компаниуд, филантропистууд татварын хөнгөлөлттэй хандив, бэлэг өгөхийг урамшуулсан эдийн засаг, эрхзүйн зохистой механизм бүрдүүлэх хэрэгтэй.

# ТӨГСГӨЛИЙН ОРОНД

- Аль ч орны сургууль хил хязгаарт баригдахааргүй өрсөлдөөнт орчинд байна. Олон улсын ранкинг, мэргэжлийн үнэлгээ, хил хязгааргүй өрсөлдөөний дүнд чанарын шалгарал явагдаж байна (Jacobs and van der Ploeg, 2005). Европын их сургуулиуд: нэгж суралцагчид зарцуулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх; үр ашгийг сайжруулах, өрсөлдөөнийг хөхүүлэн дэмжих, хувийн оролцоог нэмэгдүүлэх, ирээдүйн орлоготой холбосон зээлийн механизм, гадаад оюутны хувь хэмжээг ихэсгэх
- Өнөөдөр тэргүүлэх байранд хүрсэн систем ч цаашдаа өөрийгөө тасралтгүй сайжруулсаар байх болно.
- Монгол Улсад боловсролыг хөгжүүлэх бодлогын ерөнхий чиглэл нь нийтлэг чиг хандлагад баримжаалсан боловч, практик алхмууд нь энэ чиг хандлагаас хазайсан, тогтворгүй, өрөөсгөл шинжтэй байна. Иймд чанарын төлөөх өрсөлдөөнийг дэмжиж, академик эрх чөлөө, байгууллагын бие даасан байдлыг бэхжүүлэхэд чиглүүлэн зохицуулалтын бодлого нь тууштай байх шаардлагатай.

# REFERENCES

Монгол Улсын Боловсролын тухай хуулиуд

Fielden, J. (2008). Global Trends in University Governance, World Bank: Education Working Paper series no. 9

Jacobs, B. and van der Ploeg, F. (2006). Getting European Universities into Shape, Policy Paper 06/01, Robert Schuman Centre for advanced studies and European University Institute

Eurydice (2008). Higher Education Governance in Europe: Policies, structures, funding and academic staff, retrieved from [www.eurydice.org](http://www.eurydice.org)